

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТТАХНЭ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.24 № 06/582
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус эмнэлгийн захирал Л.Баттөр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, орлого, зардал цалингийн нэмэгдэлтэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-нөөс 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж хариуцаж хэрэгжүүлэв.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 82 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг нь “Шударга өрсөлдөөн, сонголтод суурилсан, аюулгүй, чанартай эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрд олгох олон улсын стандартад нийцсэн нөхцлийг бүрдүүлэх явдал мөн” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 тоот тушаалын 3 дугаар хавсралтын дагуу 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Хууль зүй дотоод хэргийн яамаар байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан байна.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 11 зорилтын дор 69 арга хэмжээ төлөвлөгдсөн бөгөөд хэрэгжилтийн дундаж 96.5 хувьтай байна. Үүнд:

- 100 хувийн биелэлттэй-61 арга хэмжээ
- 70 хувийн биелэлттэй-8 арга хэмжээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус эмнэлгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцсэн боловч холбогдох стандарт, хууль тогтоомжтой зарим заалтуудтай нийцэхгүй байна.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “UNICUS” программ хангамж ашигладаг байна.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 17 эрсдэлтэй асуудалд 17 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 10,864,395.0 мянган төгрөгөөс тооцон 217,287.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 286,425.9 мянган төгрөгөөр тодорхойлов.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,066,306.5 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	547,129.4	251,800.6	295,328.9
Авлага	29,306.5	2,209.2	27,097.3
Урьдчилгаа	105,228.7	88,850.0	16,378.7
Бараа материал	2,590,747.9	3,215,322.1	624,574.2
Үндсэн хөрөнгө	46,776,975.3	43,424,899.3	3,352,075.9
Нийт хөрөнгө	50,049,387.7	46,983,081.2	3,066,306.5
Өр төлбөр	502,346.5	160,119.1	342,227.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	49,547,041.3	46,822,962.0	2,724,079.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	50,049,387.7	46,983,081.2	3,066,306.5

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд 3,066,306.5 мянган төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны эцэст Хилийн 0288 дугаар ангиас Цэргийн албан хаагчдын дүрэмт хувцасны урьдчилгаанд өгсөн 19,932.7 мянган төгрөгийн хувцас, хэрэглэл, Амин зул ХХК-аас авах 3,296.0 мянган төгрөгийн ор хөнжлийн даавуу, барилгын зургийн урьдчилгаанд өгсөн 2,000.0 мянган төгрөг, Бүрэн цорс ХХК, Өлзийт одон оргил ХХК-аас авах нийт 29,023.2 мянган төгрөгийн авлагыг тус тус бүрэн барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь оны эхэнд 2,590,747.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол урсгал зардлаас тайлант хугацаанд нийт 4,743,188.9 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, тайлангийн хугацаанд 4,116,614.6 мянган төгрөгийг зарцуулснаар жилийн эцэст 3,215,322.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тухайлбал:

Жавхлант гэрэлт Од ХХК-аас эмнэлгийн бэлэн бүтээгдэхүүн буюу зөөлөн эдлэлийн данс бүртгэлд тусгасан эмч, эмнэлгийн ажилчдын эмнэлгийн хувцас, хэрэглэл, тасаг нэгжийн хэвтүүлэн эмчлүүлэгчдэд эмнэлгийн хувцсаар хангахад нийт 23 нэр төрлийн 71,233.0 мянган төгрөгийн хувцас хэрэглэл, Амин зул ХХК-аас эмнэлгийн хэвтүүлэн эмчлүүлэх тасаг нэгж болон хүүхдийн тасгийн ор хөнжлийн даавуу, дэр, хөнжил зэргийн өмнөх оны авлагаас 3,296.0 мянган төгрөг, 9 нэр төрлийн 27,360.0 мянган төгрөгийн хөнжил,

дэр, даавуу зэргийг тус тус худалдан авч дотоод гүйлгээгээр шилжүүлэн бүртгэснээр дансны үлдэгдэл өссөн байна.

Төсвийн хөрөнгөөр 480,350.5 мянган төгрөг, Төсөвт байгууллага болон бусдаас 77,075.5 мянган төгрөг, бусад байгууллагаас болон хандив тусламжаар 37,926.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус авсан байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 271 тогтоол, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалын дагуу Аварга тосон рашаан сувиллын 3 ширхэг байр 28,500.0 мянган төгрөгөөр худалдан авсан. Медигас ХХК-аар рентгений өрөөнд тугалган хамгаалалт 17,000.0 мянган төгрөг, Тулгат маргад ХХК-аар нойрны төвийн өрөөнд тасалгаа 9,000.0 мянган төгрөгөөр тус тус хийлгэж А болон Б блокийн барилгын өртөгт шингээсэн байна.

ТТАХНЭ-ийн захирлын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/103 тоот тушаалын дагуу 2019 онд тус эмнэлэгт хандив тусламжаар ирсэн нийт 19,1472 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан байна.

ТӨБЗГ-ын 2019 оны А-5/297 тоот тогтоолын дагуу тус эмнэлэгт хандив тусламжаар ирсэн нийт 9,017.5 мянган төгрөгийн хөрөнгийг тоног төхөөрөмжийн дансанд бүртгэж тайлагнасан байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 332, А-1/4444, А-1/133, 514 дугаар тогтоолын дагуу ХЗДХЯ-аас балансаас балансад шилжүүлэн ирсэн 49,450.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 22,138.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй 16,862.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй тоног төхөөрөмж, 33,630.0 мянган төгрөг, ОТТО МИР ХХК-аас 33,800.0 мянган төгрөгийн старекс маркийн авто машин худалдан авч орлого авч бүртгэсэн байна.

Тус эмнэлэг нь давсан орлогоороо Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд аварга тосон рашаан сувиллын 1000 м2 газрыг 9,500.0 мянган төгрөгөөр худалдан авсан мөн ТӨБЗГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-1/133 тоот албан бичгийг үндэслэн урсгал зардал болон нэмэлт санхүүжилтийн зардлаас 40,477.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн лиценз болон албан хэрэг хөтлөлтийн программ худалдан авсан байна.

Хасагдсан хөрөнгө:

ТӨБЗГ-ын 2019 оны 336, 475 дугаар тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1ш УАЗ-31519 маркийн 51-96 УБГ улсын дугаартай авто машин, 1ш Соната-5 маркийн 73-10 УБА улсын дугаартай авто машинуудыг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан ТТАХНЭ-ийн захирлын 2019 оны А/104 дүгээр тушаалын дагуу данс бүртгэлээс хассан байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 333 дугаар тогтоолын дагуу 120,439.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй 104,715.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 1ш рентген аппаратыг ХХЕГ-т балансаас балансад шилжүүлсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь чанарын баталгааны барьцаа чөлөөлж, хувь хүнд төлөх цалингийн өглөг буурч, тайлант хугацаанд өглөг барагдуулсантай холбоотой байна. Тайлант оны байдлаар өглөгийн дансанд бүртгэсэн 500,485.4 мянган төгрөгийн өглөг нь 2017 оноос тус эмнэлгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийн чанарын баталгааны барьцаа бөгөөд тайлант хугацаанд баталгаат хугацаа дуусаж 355,907.9 мянган төгрөг, нэмж хөрөнгө бэлтгэхтэй холбоотой үүссэн барьцаа 14,165.5 мянган төгрөгийн өглөгийг тус тус бүртгэлд тусгаж, тайлант хугацааны эцэст барьцаа дансны үлдэгдэл 158,742.9 мянган төгрөг, цус, цусан бүтээгдэхүүний өглөг 495.4 мянган төгрөг, цалингийн өглөг 370.0 мянган төгрөг, хувьд хүнд төлөх өглөг 510.7 мянган төгрөг,

нийт 160,119.1 мянган төгрөгийн өглөгтэй байна. Нийт 158,742.9 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө нь өр төлбөрийн 99.1 хувийг эзэлж байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 10,864,393.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 10,713,391.5 мянган төгрөгийг урсгал зардалд, урсгал шилжүүлэгт 151,002.4 мянган төгрөгийг зарцуулахаар батлагдсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,383,064.0 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 6,644,011.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанаас 623,983.5 мянган төгрөг, нийт 10,651,058.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаандаа 10,496,716.1 мянган төгрөгийг зарцуулж 154,342.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 862,768.9 мянган төгрөгөөр давсан нь төлбөрт тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн, урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна. Өндөр өртөгт тусламж үйлчилгээний орлогын төлөвлөгөө 213,950.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 130,362.7 мянган төгрөг буюу 83,587.3 мянган төгрөгөөр тасарсан боловч тусламж үйлчилгээний орлогоос нөхсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв:

Сангийн сайдын 2019 оны 185, 74, 251 тоот тушаалаар давсан орлого 595,856.9 мянган төгрөг, Аварга тосон амралт сувиллын 24,650.0 мянган төгрөг, төлөвлөгөөт бус Эрүүл мэндийн үзлэг хийх тухай тендерт анх удаа оролцож "Эрдэнэс таван толгой" ХК-ийн нийт 800 ажилтанд эрүүл урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээг үзүүлснээр орлого 242,261.7 мянган төгрөг, нийт 862,768.6 мянган төгрөгийн орлогыг холбогдох журмын дагуу санхүүжилтийн эрх нээлгэн авч, зарцуулсан байна.

Үүнээс цалингийн зардлын өр барагдуулахад 83,800.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 780,0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 30,918.0 мянган төгрөг, норматив зардалд 30,423.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 223,234.3 мянган төгрөг, мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 15,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 87,927.6 мянга, урсгал шилжүүлэгт 390,685.7 мянган төгрөг, нийт 862,768.6 мянган төгрөгийг тус тус зарцуулж, тайлагнасан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 17 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд шинээр эрсдэл тодорхойлох шаардлагагүй гэж үзэж нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 308,821.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 308,821.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг 2019 онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 57 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 4 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Орлого данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Нэр бүхий 3 байгууллагатай урьдчилан сэргийлэх үзлэгийн гэрээ байгуулсан боловч нийт үнийн дүнгээс 2,194.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Үүнээс 189.0 мянган төгрөгөөр илүү, 2,005.2 мянган төгрөгөөр дутуу төлсөн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгийн гэрээнд зааснаас илүү, дутуу төлсөн орлогыг хянаж гэрээ дүгнэсэн актад тодорхой тусгаж байх.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслээгүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Аливаа гэрээ, ажил үйлчилгээг дүгнэж акт, протокол үйлдэж, тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж байх;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Орлого данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Хууль зүй, дотоод хэргийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Дотоод хэргийн их сургуулийн элсэгчид,

төгсөгчид, сонсогчид, энхийг сахиулагч нарт урьдчилан сэргийлэх үзлэгт шууд хамрагдаж байна. Нийт хэдэн алба хаагч үзэхээс хэдийг үзсэн нь тодорхойгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, ашиглан залилан үүсэх;

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Аливаа гэрээ ажил үйлчилгээг дүгнэж акт, протокол үйлдэж гэрээний хэрэгжилт, орлогын хяналтыг сайжруулах;

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Орлого данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн 2019 оны төлөвлөгөө 6,912,643.1 мянган төгрөг, гүйцэтгэлээр 6,644,011.4 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байна. Үүнээс өндөр өртөгт тусламж үйлчилгээний санхүүжилтийн төлөвлөгөө 641,900.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 373,272.7 мянган төгрөг буюу 41.8 хувиар тасарсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хийсэн 2019 оны 01/102 дугаартай гэрээнд заасантай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Орлогыг бодитой төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллах, Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, ашиглан залилан үүсэх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хийсэн 2019 оны 01/102 дугаартай гэрээний хавсралт 1-т заасныг мөрдөж ажиллах, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулж байх. Цаашид өндөр өртөгт тусламж үйлчилгээг батлагдсан төсвийн дагуу хийж гүйцэтгэж байх;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4. Зардал данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Үйлчилгээний зориулалтаар түрээсэлж буй аж ахуйн нэгжээс байр ашиглалттай холбоотой түлш халаалтын зардлыг тооцож авдаггүй, гэрээнд тусгаагүй байна.

Энэ нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 123 дугаар тогтоолд заасантай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулах;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах, аливаа гэрээ ажил үйлчилгээнд тавих дотоод хяналтыг сайжруулах;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.5. Зардал данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт аварга тосонд байрлах 1000 м.кв амралт үйлчилгээний зориулалтаар баригдсан 3 ширхэг өвлийн байшин, газрын хамт 38,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4-т “төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх;

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4-т заасныг мөрдөж ажиллах, хөрөнгө бэлтгэх, актлахад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандаж зөвшөөрөл авч байх;

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.6. Зардал данстай холбоотой асуудал

3.6.1 Илрүүлэлт:

Тус эмнэлэг нь "Очир принтинг" ХХК-тай 2017 оны ХА/17/15 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч түрээсийн гэрээ байгуулаагүй, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2-т “түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 /дөчин/ хувиар тогтоосугай” гэж заасныг зөрчсөн байна.

3.6.2 Эрсдэл:

Орлогыг бодитой төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллах, Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, ашиглан залилан үүсэх;

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2-т заасныг мөрдөж ажиллах, түрээсийн гэрээний орлогыг төвлөрүүлж байх;

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.7. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.7.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хүчингүй болсон тушаал, шийдвэрийг шинэчлэх ажлыг хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.7.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, хүчин төгөлдөр хууль журамд үндэслэхгүй байх;

3.7.3 Өгсөн зөвлөмж:

УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар, журам байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулан мөрдөж ажиллах;

3.7.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.8. Цалингийн данстай холбоотой асуудал

3.8.1 Илрүүлэлт:

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтад заасан "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам"-д заасныг зөрчсөн байна.

3.8.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэхгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

3.8.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах;

3.8.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,272,412,449.72	3,558,181,828.08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	547,129,415.00	251,800,556.61
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	547,129,415.00	251,800,556.61
3121	Төгрөг	547,129,415.00	251,800,556.61
31211	Төрийн сангийн харилцах	547,119,415.00	251,790,556.61
